




МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2024-2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Дэлхий даяар цар тахал намжаагүй, олон улс оронд инфляц зорилтот түвшнээсээ давсан, олон улсын хямралт нөхцөл байдал хэвээр байгаа нь 2023 оны дэлхийн эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хүрээнд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын дараах улс орны эдийн засаг эрчимтэй сэргэж байгаагаас үүдсэн үнийн өсөлтийг зорилтод түвшинд барих, боомтын сэргэлтийг эрчимжүүлэн экспортоос орох төсвийн орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй төсөл хөтөлбөрт чиглүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд “Шинэ сэргэлтийн бодлого”-д чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан эдийн засгийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлах тухай нэг зүйлтэй байна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэл дэх эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцож, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэмжих төсвийн бодлогыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг

хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

--- оОо ---